



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026.04.23 № 05/320

танай _____-ныг № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн нэр бүхий ажилтнуудаас 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн “Тус төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинбатын удирдлагын үйл ажиллагаанд ноцтой зөрчил, доголдлууд гарч байгууллагын хэвийн үйл ажиллагаа, ажилчдын хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлж байна. Удирдлагын хэрэгжүүлж буй зохион байгуулалт, арга барил нь хамт олны уур амьсгалыг алдагдуулж ажилтнуудын хооронд итгэлцэл хамтын ажиллагаа суларч, шууд харилцаа эрс багасаж, эрүүл эерэг ажлын орчин алдагдсан. Ажлын байрны тэгш, шударга орчны зарчим ноцтой зөрчигдөж ялгаварлан гадуурхалт, үл итгэлцэл, сөрөг хандлага үүсгэж байна. Ажлын шийдвэр хувь хүний нөлөөнд автсан, бодит нөхцөл байдал, мэргэжлийн үндэслэл, хамт олны санал, ил тод, хариуцлагатай байдлыг алдагдуулж байна. Удирдах манлайлал сул, томилгоо хууль, дүрэм зөрчсөн” гэх агуулга бүхий гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5-д заасны дагуу дотоод хяналт, шалгалт хийж дараах зөвлөмжийг танд хүргүүлж байна. Үүнд:

1. Удирдах дээд байгууллага болон аймгийн захиргаанаас өгч буй мэдээ мэдээллийг нийт алба хаагчдад танилцуулан шуурхай хурал хийж тэмдэглэл хөтөлж хэвших, гадаад дотоодын сургалт семинарын талаар мэдээлэл бэлтгэж хамт олондоо танилцуулах, удирдлагын манлайллыг бий болгож ажил сайжруулах;

2. Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоонд ажиллаж байгаа усны харуулд туслах гэрээт ажилтны орон тоо тусгагдаагүй тул ажилтны амь нас эрүүл мэндийг хамгаалж, Орхон-Орхон, Сэлэнгэ-Хялганат, Сэлэнгэ-Хутаг, Орхон-Сайхан, Эг-Хантай зэрэг 5 усны хэмжилтийн цэгт усны автомат станцыг усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос худалдан авах боломж нөхцөлийг судалж, Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх;

3. Захиргааны баримт бичиг болон нийт албан бичиг баримтад “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Баримт бичгийн стандарт MNS 5140 – 2021”-ыг мөрдөж, хяналт тавьж ажиллах;

4. Алба хаагчийн албан тушаал өөрчлөгдөх, ажлаас халах тохиолдолд Захиргааны ерөнхий тухай хуулийн 27 дугаар зүйл “Сонсох ажиллагаа явуулах”-ийг хийж байх;

1526020277

5. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллан байгууллагын доторх үйл ажиллагаагаа ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг мөрдөж, нэгдсэн мэдээллийг өгч, хамт олны дотор ажил хэрэгч уур амьсгалыг бий болгож үр дүнг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ОЮУНБИЛЭГ